



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 26 өдөр

Дугаар А/112

Жаргалтхаан сум

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4-д заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрхээ шилжүүлэх тухай хүсэлт ирүүлсэн иргэн Цэрэнсамбуугийн Өлзийт (СМ76051414)-ийн хүсэлтийг судлан үзээд, Жаргалтхаан сумын 5-р баг Төвийн, Урт 406 хаягт байрлах, 2319002102 нэгж талбарын дугаартай, худалдаа нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолборын зориулалттай 2000 квадрат метр газрын эзэмших эрхийг иргэн Энхтүвшингийн Батболд (СМ89043015)-д шилжүүлсүгэй.

2. Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд газар эзэмшигчийн эрх, үүргийг хэрэгжүүлж, төрийн эрх бүхий байгууллагаас газар ашиглалттай холбогдуулан тавьсан нийтлэг шаардлагыг биелүүлэхийг газар эзэмшигчид даалгасугай.

3. Газар эзэмшигч иргэнтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, гэрчилгээ олгох, кадастрын болон улсын бүртгэлд бүртгэхийг сумын газрын даамал (Н.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжтай холбогдуулан иргэн Ц.Өлзийтийн эзэмшлийн 0000033060 дугаартай газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

С.ГАНБАТ

